



## ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭ: БАНКНЫ ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 28 –ны өдрийн ээлжит хуралдаанаар Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг баталлаа. Тус хуулийн дагуу Монгол улсын Банкны тухай хуульд дараах гол өөрчлөлтүүд орсон байна.

### БАНКНЫ ХЭЛБЭР

Судалгаагаар Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын хувьцаа эзэмшил нь 1-3 тооны хувьцаа эзэмшигчдэд хэт төвлөрч, өмчлөл-хяналтын харилцан тэнцвэр алдагдаж, ашиг сонирхлын зөрчлөөс үүдэлтэй банкны хүлээж болох эрсдлийн түвшин нэмэгдсэн, энэ нь зарим тохиолдолд банкныг төлбөрийн чадваргүй болгон төр, нийт хохирох байдал гарч байгаа тул банкны хэлбэрийг “НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ” байхаар тогтоожээ.

### БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

Банкны үйл ажиллагааг хувьцаат компанийн хэлбэрээр явуулах шаардлагатай холбогдуулан хувьцаа эзэмшилд тавигдах тоо хэмжээний хязгаарлалтыг дараах байдлаар тогтоосон байна:

- Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны хэмжээ тухайн банкны нийт гаргасан хувьцааны **хорин хувиас /20%/** хэтрэхгүй байна.
- Дээрх хязгаарлалт нь дараах тохиолдолд хамаарахгүй:
  - ✓ Засгийн газраас үүсгэн байгуулсан банк болон тусгай зориулалтын банк;
  - ✓ Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуульд заасны дагуу төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банкны төрийн эзэмшлийн хувьд.

Мөн хувьцаа эзэмшигчдийн үйл ажиллагаанд зарим нэг хязгаарлалт тогтоож, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид тавигдах шалгуурыг тодорхойлжээ. Үүнд:

- Иргэн, хуулийн этгээд бусдын нэрийг ашиглан банкны хувьцааг шууд бус хэлбэрээр эзэмшихийг хориглоно.
- Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд өөр банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно.

- Банкны үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш нэг жилийн хугацаанд банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид зээл олгохыг хориглоно.
- Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч дараах шалгуурыг хангасан байна.
  - ✓ Тухайн этгээд нь дампуурлын хэргийн хариуцагч, эсхүл хариуцагч хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан бус байх;
  - ✓ Эдийн засаг, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг үйлдэж байгаагүй;
  - ✓ Санхүүгийн чадавхтай байх;
  - ✓ Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол тухайн нэгдэл нь Монголбанкнаас хяналт шалгалт хийх боломж бүхий бүтэцтэй байх;
  - ✓ Тухайн хувьцааны эцсийн өмчлөгчийг хангалттай нотолсон байх;
  - ✓ Өөрөө, эсвэл нэгдмэл сонирхолтой этгээд, эцсийн өмчлөгч нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын Гишүүн, Засгийн Газрын гишүүн биш байх эсвэл төрийн өндөр албан тушаалд хамаарах улс төрийн албан тушаалтан биш байх.

## **БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) ес ба түүнээс дээш гишүүнтэй байх бөгөөд нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна. Энгийн хувьцаат компаниас ялгаатай нь банкны ТУЗ –ийн гишүүнийг сонгосон хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр Монголбанкны зөвшөөрснөөр хүчин төгөлдөр болно. Түүнчлэн банкны ТУЗ –ийн дарга болон гишүүнд дан ганц банкны төдийгүй банкны харилцагчийн эрх ашгийг хувийн болон өөрийг нь сонгосон этгээдийн эрх ашгаас дээгүүр тавих үүрэг хүлээлгэсэн.

## **МОНГОЛБАНКНЫ(МОНГОЛЫН ТӨВ БАНК) ОРОЛЦОО**

Хуулинд орсон өөрчлөлтүүдээс үзвэл, Монголбанкны зүгээс банкны үйл ажиллагаанд тавих хяналт нэмэгдсэн байна. Тухайлбал:

- Банк нь Банкны тухай хууль тогтоомж, Монголбанкнаас тогтоосон дүрэм, журам, шийдвэрийг зөрчсөн, эсхүл зөрчиж болзошгүй нөхцөл байдал үүссэн, банкны тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаагүй, эсхүл найдваргүй, хэвийн бус үйл ажиллагаа явуулсан бол Монголбанк Банкны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан үндэслэлээр банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.
- Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт орох, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах болон өөрийн хөрөнгийн хэмжээг өөрчлөх аливаа хэлцэл хийх бол банк энэ талаар тухай бүр нь Монголбанкинд бичгээр урьдчилан мэдэгдэнэ.
- Аливаа этгээд нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болсон, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн (хувь хүн, хуулийн этгээд) хувьцааны хэмжээ, бүтцэд өөрчлөлт орсон бол банк нь Монголбанкинд ажлын 10 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.
- Монголбанк банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ, бүтцэд өөрчлөлт орох, хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас нэмж гаргах зөвшөөрөл

хүссэн өргөдлийг хүлээн авч, Банкны тухай хуульд заасан шаардлага, шалгуурыг хангасан, баримт бичиг бүрэн гүйцэд бүрдсэнээс хойш 60 хоногийн дотор зөвшөөрөл олгох эсэх тухай шийдвэр гаргаж энэ талаар банкинд мэдэгдэнэ.

- Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулахыг Монголбанк зөвшөөрөөгүй, эсхүл хуульд заасан шаардлага, шалгуурыг хангаагүй бол тухайн хувьцаа нь саналын эрхгүй, ногдол ашиг авах эрхгүй бөгөөд зөвшөөрөгдөөгүй хэмжээгээр банкны өөрийн хөрөнгөөс хасч тооцож, бусдад худалдах буюу шилжүүлнэ.
- Монголбанк нөхцөлт удирдлага<sup>1</sup> хэрэгжүүлэхдээ шаардлагатай тохиолдолд банкны хувьцаа эзэмшигчийн саналын эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Дараах үйл ажиллагааг Монголбанкны зөвшөөрөлтэйгээр явуулна:

- Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг банкинд буцаан худалдах;
- ТУЗ –ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох.

Мөн банкны Гүйцэтгэх удирдлагыг Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр томилно.

## **БУСАД**

- Эцсийн өмчлөгчийн тодорхойлолтод өөрчлөлт оруулж, эцсийн өмчлөгч нь хувь хүн байна гэдгийг тодорхой болгожээ: “Банкны үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг, эсхүл өөрийн энэ эрхээ бусдаар төлөөлүүлэн гүйцэтгүүлдэг, эсхүл банкны хувьцааг нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдээр дамжуулан эзэмшиж байгаа, тухайн хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан буюу банкны хувьцаа, үйл ажиллагаанаас үүсэх үр шимийг хүртэх эрх бүхий **өмчлөгч хүн**”<sup>2</sup>.
- Мөн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид “банкны хувьцааны эцсийн өмчлөгчийн эрхийг **шууд бусаар** хэрэгжүүлдэг этгээдийг” хамруулжээ. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны эцсийн өмчлөгчийг тодорхойлсон мэдээлэл, холбогдох баримт бичгийг Монголбанкинд ирүүлэх бөгөөд эцсийн өмчлөгч өөрчлөгдөх бүрт уг мэдээллийг шинэчилж ирүүлнэ.
- Банкны гаргасан хувьцааг худалдан авах хөрөнгө нь мөнгөн хөрөнгө байна.

Эх сурвалж:

1. Банкны тухай хуулийн төсөл - <http://forum.parliament.mn/projects/10926>.

## **Анхаар:**

<sup>1</sup> Монголбанкны хяналт шалгалтаар төлбөрийн чадвар муудаж байгаа нь тогтоогдсон бол тухайн банкны хэвийн үйл ажиллагааг хангах, санхүүгийн байдлыг нь сайжруулах зорилгоор банкны удирдлага, зохион байгуулалт, санхүү, үйл ажиллагаатай нь холбогдуулан хуульд заасны дагуу Монголбанкнаас авч хэрэгжүүлэх цогц арга хэмжээ (3.1.16, Банкны тухай хууль)

<sup>2</sup> Урд нь “өмчлөгч этгээд” гэж тодорхойлж байв.

*Энэхүү материалыг ГРАТА Интернэшнл Монголиа хуулийн фирм бэлтгэн хүргэж байна. Дээрх материал нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд энд тайлбарласан зүйл тус бүрт нарийвчлан дүн шинжилгээ хийгээгүй болно. Уншигч та ямар нэг арга хэмжээ авахын өмнө (эсвэл авахгүй байх тохиолдолд) өөрсдийн нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэхүү мэдээлэлд үндэслэн хийсэн аливаа үйлдэл/эс үйлдэлд Грата Интернэшнл Монголиа аливаа хариуцлага хүлээхгүй болохыг анхаарна уу.*

***Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл, GRATA International Хуулийн Фирмийн партнер В.Болормаа болон эрх зүйч Т.Буянжаргалмай [bvolodya@gratanet.com](mailto:bvolodya@gratanet.com), [btungalag@gratanet.com](mailto:btungalag@gratanet.com) эсхүл +976 70155031 утсаар холбогдоорой.***